

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/220/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
 5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....
-

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
СЯ	Соёлын яам
СУГ	Соёл урлагийн газар

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН СОЁЛ
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА
К.БЕКЖАН ТАНАА

2023.02.17 № 65
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Соёл урлагийн газар нь тайлант онд аймгийн соёлын салбарын харьяа байгууллагуудыг удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* М.ХУАНГАН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,608,386.00</u>	<u>31,351,400.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	25,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	25,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,608,386.00	6,351,400.00
354	Хангамжийн материал	6,608,386.00	6,351,400.00
35410	Бичиг хэргийн материал	507,000.00	1,340,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,364,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	3,145,986.00	2,970,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,591,400.00	2,041,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>38,240,519.97</u>	<u>68,580,638.82</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	38,240,519.97	68,580,638.82
392	Биет хөрөнгө	37,598,853.30	66,658,972.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	-
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,000,000.00	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6,319,444.43)	(12,152,777.75)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,838,900.00	36,194,818.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(121,643.76)	(5,778,690.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,227,941.00	14,487,941.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,899.51)	(1,092,318.36)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	-
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	-
393	Биет бус хөрөнгө	641,666.67	1,921,666.71
39301	Програм хангамж	660,000.00	2,160,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(18,333.33)	(238,333.29)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	-
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>44,848,905.97</u>	<u>99,932,038.82</u>

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>44,848,905.97</u>	<u>99,932,038.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	44,848,905.97	99,932,038.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	44,848,905.97	99,932,038.82
51210	Өмнөх үеийн үр дүн	-	44,848,905.97
51220	Тайлант үеийн үр дүн	44,848,905.97	55,083,132.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>44,848,905.97</u>	<u>99,932,038.82</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	60,576,796.57	367,924,450.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,451,396.57	28,986,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,451,396.57	28,986,750.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	33,451,396.57	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	33,451,396.57	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	28,986,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,125,400.00	338,937,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	212,162,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	212,162,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	96,775,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		35,325,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	61,450,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,125,400.00	30,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,125,400.00	30,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,724,734.29	312,841,317.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,724,734.29	312,841,317.15

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,724,734.29	274,441,011.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,095,200.00	110,147,912.65
210101	Үндсэн цалин	8,095,200.00	89,265,044.35
210102	Нэмэгдэл		9,930,466.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		9,885,509.30
210104	Урамшуулал		1,066,893.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,011,857.69	13,768,492.13
210201	Тэтгэврийн даатгал	1,011,857.69	9,362,576.81
210202	Тэтгэмжийн даатгал		1,101,479.10
210203	ҮОМШӨ-ний даатгал		881,183.15
210204	Ажилгүйдлийн даатгал		220,295.95
210205	Эрүүл мэндийн даатгал		2,202,957.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,750,000.00	30,000,000.00
210304	Байрны түрээс	3,750,000.00	30,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	680,000.00	24,974,186.00
210401	Бичиг хэрэг	282,000.00	4,841,200.00
210402	Тээвэр, шатахуун	398,000.00	18,481,486.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,136,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		274,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		240,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,413,900.00	2,514,582.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	14,582.00
210604	Урсгал засвар	1,413,900.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	483,000.00	3,500,000.00
210702	Дотоод албан томилолт	483,000.00	3,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,900.00	6,919,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		6,919,790.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	123,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,876.60	82,616,049.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	70,074,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	166,876.60	12,542,049.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	38,400,305.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	823,383.00
з	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		823,383.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	37,576,922.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		37,576,922.22
213304	Хөрөнгийн	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
222001	Тоног төхөөрөмж	-	-
223001	Бусад хөрөнгө	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	44,852,062.28	55,083,132.85

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225003	Хөрөнгө оруулалтын гарз	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	44,852,062.28	55,083,132.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	=	338,937,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	338,937,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	212,162,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	212,162,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	96,775,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		35,325,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		61,450,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	30,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		30,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	=	325,042,282.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	325,042,282.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	286,641,976.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	110,147,912.65
210101	Үндсэн цалин		89,265,044.35
210102	Нэмэгдэл		9,930,466.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		9,885,509.30
210104	Урамшуулал		1,066,893.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	13,768,492.13
210201	Тэтгэврийн даатгал		9,362,576.81
210202	Тэтгэмжийн даатгал		1,101,479.10
210203	ҮОМШӨ-ний даатгал		881,183.15
210204	Ажилгүйдлийн даатгал		220,295.95
210205	Эрүүл мэндийн даатгал		2,202,957.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	30,000,000.00
210304	Байрны түрээс		30,000,000.00

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	-	25,406,200.00
210401	Бичиг хэрэг		5,449,200.00
210402	Тээвэр, шатахуун		18,305,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,136,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		274,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		240,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	27,604,582.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		104,582.00
210602	Тавилга		20,000,000.00
210604	Урсгал засвар	-	7,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	3,500,000.00
210702	Дотоод албан томилолт		3,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	7,144,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,144,790.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	69,070,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		69,070,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	38,400,305.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	823,383.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		823,383.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	37,576,922.22
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		37,576,922.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>13,895,418.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	13,895,418.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	13,895,418.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	13,895,418.00
223001	Бусад хөрөнгө		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		13,895,418.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(13,895,418.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			44,848,905.97	44,848,905.97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	44,848,905.97	44,848,905.97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	44,848,905.97	44,848,905.97
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	44,848,905.97	44,848,905.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	44,848,905.97	44,848,905.97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-			-
D08	Тайлант үеийн үр дүн			55,083,132.85	55,083,132.85
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	99,932,038.82	99,932,038.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	242,162,700.00	204,585,777.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242,162,700.00	204,585,777.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239,889,800.00	203,762,394.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,689,800.00	110,147,912.65
210101	Үндсэн цалин	93,567,000.00	89,265,044.35
210102	Нэмэгдэл	10,852,400.00	9,930,466.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,150,000.00	9,885,509.30
210104	Урамшуулал	1,120,400.00	1,066,893.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,232,200.00	13,768,492.13
210201	Тэтгэврийн даатгал	14,437,900.00	9,362,576.81
210202	Тэтгэмжийн даатгал	1,698,600.00	1,101,479.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,358,900.00	881,183.15
210204	Ажилгүйдлийн даатгал	339,700.00	220,295.95
210205	Эрүүл мэндийн даатгал	3,397,100.00	2,202,957.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,000,000.00	30,000,000.00
210304	Байрны түрээс	30,000,000.00	30,000,000.00

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	15,289,000.00	12,306,200.00
210401	Бичиг хэрэг	4,113,000.00	3,949,200.00
210402	Тээвэр, шатахуун	7,000,000.00	6,705,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,474,200.00	1,136,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	461,000.00	274,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,800.00	240,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,000,000.00	25,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга	20,000,000.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,665,400.00	8,644,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,665,400.00	8,644,790.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,013,400.00	3,895,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,013,400.00	3,895,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,272,900.00	823,383.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,272,900.00	823,383.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,272,900.00	823,383.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	242,162,700.00	204,585,777.78
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	212,162,700.00	174,585,777.78
131001	Улсын төсвөөс санхүүжих	212,162,700.00	174,585,777.78
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,000,000.00	30,000,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	30,000,000.00	30,000,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	5	5
620003	Үйлчлэх ажилтан		
620004	Гэрээт ажилтан		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6	6
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	5	5
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1	1

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,000,000.00	96,775,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,000,000.00	96,775,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,000.00	96,775,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,856,000.00	13,100,000.00
210401	Бичиг хэрэг	589,000.00	1,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,267,000.00	11,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,144,000.00	15,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		9,500,000.00
210602	Тавилга		3,000,000.00
210604	Урсгал засвар	1,144,000.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	3,500,000.00
210702	Дотоод албан томилолт		3,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	65,175,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		65,175,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,000,000.00	96,775,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	96,775,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		35,325,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	61,450,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газар нь соёл, урлагийн салбарын төрийн удирдлагын үйл ажиллагааг явуулдаг Соёлын яамны харьяа байгууллага юм.

Аймгийн Соёл, урлагийн газар нь 2022 онд харьяа байгууллагуудыг төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилт, соёлын үйл ажиллагаа эрхлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилго дэвшүүлэн ажилласан байна. Үүнд Уламжлалыг өвлүүлэн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, хадгалах, хамгаалах “Түүх соёлын үл хөдлөх хөрөнгийн тооллого”-ыг бүтэн жилээр хийж дүгнэж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль журмыг ашигладаг байна. Үүнд:

- Соёлын тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нийгмийн даатгал, Татварын тухай хууль гэх мэт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ. Тус байгууллагад дотоод аудитын нэгж ажилладаггүй.

Тайлант онд Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоодын аудитын газраас Соёлын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд шалгалт хийгдэж тус газрын шилэн дансны мэдээлэл хангалтгүй хэрэгжүүлсэн 16 асуудлыг илрүүлж, зөвлөмж өгч ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аймгийн Соёл урлагийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Соёл урлагийн газар нь Монгол Улсын Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ны А/02 дугаар тушаалаар баталсан Соёлын сайдын эрхлэх асуудын хүрээний байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55.1 сая төгрөгөөр буюу 122.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага		25,000.0	25,000.0
Бараа материал	6,608.4	6,351.4	(257.0)
Үндсэн хөрөнгө	38,240.5	68,580.6	30,340.1
Нийт хөрөнгө	44,848.9	99,932.0	55,083.1
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	44,848.9	99,932.0	55,083.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	44,848.9	99,932.0	55,083.1

Хүснэгтээс харахад өмнөх оноос бараа материалын данс 0.2 сая төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгийн данс 30.3 сая төгрөгөөр, Засгийн газрын хувь оролцоо данс 55.1 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгө үлдэгдэлгүй. Оны эхэнд авлагагүй, оны эцэст 2023 онд шинээр барилгад ороход шаардлагатай тавилга эд хогшил, засварын зардлын 25.0 сая төгрөгийг гүйцэтгэгч компанид урьдчилан шилжүүлэн авлага үүсгэсэн байна.

Бараа материалын данс оны эхэнд 6.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр нийт 19.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 20.2 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 6.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 38.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 13.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 19.8 сая аймгийн ОНХС-гаас, 7.6 сая Соёлын яамнаас, аймгийн ИТХ-ын 2022 оны 90 дүгээр тогтоолоор Ногооннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн балансаас 1.9 сая төгрөгийн дансны үнэтэй, 0.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 2 ширхэг компьютер зэрэг үнэ төлбөргүй тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь 2021 оны 11 дүгээр сард байгуулагдсан тул 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн санал авагдаагүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны эхэнд батлагдсан төсөвт нийт дүнгээрээ өөрчлөлт ороогүй, цалингийн хөлсний зардлын нэмэгдлийн төсвөөс тавилга эд хогшилд 20.0 сая, урсгал засварын 5.0 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 20.0 сая нийтдээ 45.0 сая төгрөгийн төсөв хооронд шилжүүлэн тодотгож баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 212.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 30.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 242.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 174.6 сая, орон нутгийн төсвөөс 30.0 сая бүгд 204.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцэст 37.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 204.6 сая төгрөг буюу 84.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 37.6 төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн хэмнэлтээс үзэхэд тус газрын цалингийн зардлаас бусад зардлын төсөв их хэмжээгээр хэмнэлттэй гарсан нь 2022 оны батлагдсан төсөв үндэслэлгүй хийгдсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	239,889.80	203,762.4	-36,127.40	84.9
2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,272.90	823.40	-1,449.5	36,2
	Дүн	242,162.70	204,585.80	-37,576.90	121.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Соёл урлагийн газар нь дээд шатны байгууллагаас 61.5 сая төгрөгийн, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 35.3 сая төгрөгийн нийтдээ 96.8 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж ажилласан байна.

Зарцуулалтыг үзэхэд: хангамж, бараа материалын зардалд 13.1 сая, томилолт, эд хогшил, урсгал засварын зардалд 15.0 сая, томилолт, зочны зардалд 3.5 сая төгрөгийн, Бараа үйлчилгээний бусад зардалд 65.2 сая төгрөгийн тус тус зарцуулах эрх авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Соёл урлагийн газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 15.7 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 0.3 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 312.8 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

Соёлын урлагийн газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 297.1 сая төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзсэн. Энэхүү өсөлт тус газар нь 2021 оны 11 дүгээр сард шинээр байгуулагдсантай холбоотой их хэмжээний өөрчлөлттэй харагдаж байна.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бараа, үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан. Тухайлбал: цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлаас 13.0 сая, хангамж бараа материалын зардлаас 3.0 сая, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 0.02 сая, бараа үйлчилгээний бусад зардлаас 20.1 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 1.4 сая төгрөгийг хэмнэж зарцуулсан.

Хот дотор албан ажлаар 1878 км-т 1.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан, жилийн эцэст 1.9 сая төгрөгийн тээвэр шатахууны талоны үлдэгдэлтэй гарч нөөц үүсгэсэн зэргээр төрийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Соёлын урлагийн газар нь 2022 онд нийт 297.7 сая төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 147 мэдээллийг хугацаандаа оруулж, 4 мэдээлэл буюу 85.4 сая төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%, хугацаа хоцролын хэрэгжилтийн хувь 79.2% байна.

Тайлант онд Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоодын аудитын газраас Соёлын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2022 оны 3-р улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд шалгалт хийгдэж тус газрын шилэн дансны мэдээлэл хангалтгүй хэрэгжүүлсэн 16 асуудлыг илрүүлж, зөвлөмж өгч ажилласан тул дээрх зөрчлийг давхардуулж зөрчил бичигдээгүй болно.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Соёл урлагийн газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчилтэй асуудал гараагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 411.7 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 411.7 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: 1. Санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардлыг авлагаар бүртгэж тайлагнасныг залруулсан.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайланг нэмэлт санхүүжилт, төвлөрүүлсэн санхүүжилтийг цэвэрлээгүй алдаатай тайлагнаж ирүүлснийг нийт дүнгээр залруулга хийв. Сангийн яамны Э-тайлангийн төсвийн гүйцэтгэлийн төсвийн тайлангийн тохируулах бичилтийг дутуу хийснийг тус тус залруулав.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр дараах 22.4 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1.Тайлант онд 11.4 сая төгрөгийн тээвэр шатахуун худалдан авч, 11.6 сая төгрөгийн шатахуун зарцуулснаас хот дотор албан ажлаар 1878 км-т 1.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан, жилийн эцэст 3.0 сая төгрөгийн тээвэр шатахууны талоны үлдэгдэлтэй гарч нөөц үүсгэсэн зэргээр төрийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлээгүй.

2. Оны эцэст тавилга эд хогшил бэлтгэх зорилгоор 20.0 сая төгрөгийн “Мега шийдэл” ХХК-нд, урсгал засвар хийлгэхээр 5.0 сая төгрөгийн “Репресент” ХХК-нд нийтдээ 25.0 сая төгрөгийг нийлүүлэгч компанид шууд шилжүүлж авлага үүсгэсэн.

3. Төрийн сангийн харилцах данснаас нярвын арилжааны банкин дахь хувийн дансанд 18.2 сая төгрөгийг шилжүүлж зарцуулж, кассын тайлан гаргаагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Урьдчилж гарсан зардлыг авлагаар бүртгэж тайлагнасан.	1	25,000.0			1	25,000.0	1	25,000.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайланг алдаатай илэрхийлсэн.	1	386,748.5			1	386,748.5	1	386,748.5				
Дүн	2	411,748.5			2	411,748.5	2	411,748.5				

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн н акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хот дотор 1.2 сая төгрөгийн шатахуун зарцуулж, 1.9 сая төгрөгийн шатахууны талоны үлдэгдэлтэй гарсан.	1	4,173.7			1	4,173.7						
Нийлүүлэгч компанид мөнгөн шилжүүлж авлагаар тайлагнасан.	1	0.00			1							
Нярвын хувийн дансаар зарцуулсан мөнгөний кассын тайлан гаргаагүй	1	18,232.5			1	18,232.5						
Дүн	3	22,406.2			3	22,406.2						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит
